

ТОДРУУЛГЫН ХАРИУ

№	Тодруулга	Хариу
1	<p>“Зөвлөх үйлчилгээний үр дүн хэсэгт” Шинэчлэн боловсруулж батлуулсан “Авто зам, замын барилгын ажлын жишиг техникийн шаардлага” гэж тусгажээ. Авто зам, замын барилгын ажил гэж таслалаар салгасан нь ойлгомжгүй байна. Баримт бичгийн нэрийг “Авто замын барилгын ажлын жишиг техникийн шаардлага” гэж ойлгож болох уу?</p>	<p>Шинэчлэн боловсруулсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” гэж ойлгоно.</p>
2	<p>Энэхүү баримт бичиг нь ЗЗБНБД байх нь зөв үү? Харин эсрэгээрээ, ямар нэгэн Норм ба Дүрэм Стандарт зэрэг заавал мөрдөх бус, мөн талбайд хийгдэж буй барилгын аливаа ажилд хэрэглэхгүй, түүнчлэн зөвхөн авто замын зураг боловсруулах компаниуд зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу зохиох тухайлсан объектын зургийн иж бүрдэлд орсон ажлуудын Техникийн шаардлагыг боловсруулах үйл ажиллагаандаа бүтэц, агуулга, хэлбэр, загвар гэх мэтэд ерөнхий төсөөлөл, санаа авах, тойм жишиг болгох байдлаар хэрэглэх зориулалт бүхий баримт бичиг байх ёстой гэж ойлгож байна, энэ зөв үү?</p>	<p>Шинэчлэн боловсруулсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” -ыг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулах бөгөөд тус байгууллага нь зохих журмын дагуу шифр дугаар олгоно.</p>
3	<p>ЗТХСайдын 2021 оны А/123 дугаар тушаалаар “Гүүр ба хоолойн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” батлагдсан бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Гэтэл “Зөвлөх үйлчилгээний ажил үүрэг” хэсэгт тус техникийн шаардлагын “<i>Хоолой ус зайлуулах байгууламж, гүүрэн байгууламжийн ажлын шаардлага, барих аргачлалтай уялдуулах</i>” гэж оруулсан нь ямар учиртай вэ? ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” болон ЗЗБНБД 31-001-2021 “Гүүр ба хоолойн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-уудад “хоолой ба ус өнгөрүүлэх бусад байгууламж” гэсэн бүлгүүд давхардсан, дотор нь бас зөрүүтэй шаардлагууд ч байгаа. Ер нь ус зайлуулах хоолой, бусад байгууламж, жижиг гүүр нь замын ажлын бүтцэд хамаардаг тул тэдгээр нь замын барилгын ажлын жишиг техникийн шаардлагад байх нь зөв хэмээн үзэж байна. Энэ зөв үү? Үгүй бол тайлбарлаж өгнө үү?</p>	<p>Ус зайлуулах хоолой, бусад байгууламж, жижиг гүүр нь замын ажлын бүтцэд хамаардаг тул тэдгээр нь Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлагад байх нь зүйтэй ба Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/123 дугаар тушаалаар батлагдсан ЗЗБНБД 33-001-2021 “Гүүр ба хоолойн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” -д тусгагдсан шаардлагуудтай уялдуулах.</p>
4	<p>“Хэрэгцээ шаардлага хэсэгт” “Зураг төслийн байгууллагууд тухайн төсөлд зориулсан техникийн шаардлага боловсруулан гаргаж байгаа нь өөр хоорондоо зөрүүтэй байгааг арилгах” гэжээ. Ажлын даалгаврын энэхүү заалтаар бол дээрх дутагдлыг нэлэнхүйд нь хаацайлах зоилготой, үүүд ашигладаг баримт бичиг боловсруулагдахаар ойлгогдож байна. Зүй нь Техникийн шаардлага нь зөвхөн “ТУХАЙН Объектын ажилд тавигдах шаардлагыг тодорхойлдог”, тэр тусмаа объект бүхэн олон талаараа их, бага ялгаатай тул техникийн шаардлага нь ижил байж огт таарахгүй. Асуудлыг ийм байдлаар нэг мөр журамлах оролдлого нь мэргэжлийн бус,</p>	<p>Зураг төслийн байгууллагууд нь батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-ыг тойм жишиг байдлаар хэрэглэх, тухайн төсөлд тусгайлан ТШ боловсруулах үүрэг хариуцлагыг сайжруулах, алдаа дутагдлыг арилгах зорилгоор асуудлыг тодорхойлсон болно. Уг заалтын найруулгыг залруулна.</p>

	ёс зүйгүй үйлдэл болох тул давуу байдлын эрмэбээрээ Барилгын гэрээний иж бүрдэлд зургийн дээр байдаг техникийн шаардлагыг дагнан боловсруулах ёстой хуулийн этгээдийн үүрэг ба эрхэд халдахгүй байх нь зүйтэй болов уу. Иймд энэ заалтыг хасч болох уу?	
5	Ажлын даалгаварт мөн дээрх алдаа дутагдал зөрчлийг арилгах зорилгоор “Авто замын салбарт шинээр нэвтэрч байгаа орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологийг хамарсан авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлагатай болсон байх” гэж заасан байна. Захиалагч ямар нэгэн замын зураг захиалахдаа ямар шинэ техник, технологи нэвтрүүлэхийг зааж өгөх, эсвэл Зураг зохиогч инженерийн шийдэлдээ ямар шинэ зүйлийг тусгах нь тухайн газар нутгийн онцлог, цаг үеийн асуудал байж таарах байх. Иймээс тэдгээрийг урьдчилан таамаглах, яг ямар технологийг сонгож жишиг техникийн шаардлагад оруулах нь боломжгүй юм. Үүнийг хасах уу? Тайлбарлаж өгнө үү?	ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-д тусгагдаагүй, Монгол оронд нэвтэрсэн техник, технологийн шаардлагыг тогтоож, шинэчилсэн төсөлд тусгах гэж ойлгоно.
6	Хотын гудамж, зам барих техникийн шаардлага тусдаа байх ёстой болов уу? Иймээс энэхүү ЖТШ-д орох зүйл байхгүй тул Нийслэлийн авто замын хөгжлийн газартай зөвшилцөх шаардлагатай гэснийг хэрхэн ойлгох вэ?	Шинэчилэн боловсруулсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-ын төсөлд санал авч ажиллана.
7	“Зөвлөхийн үйлчилгээний зорилго хэсэгт” ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-ийн үндсэн параметруудийг дахин хянаж, шинээр боловсруулах, шинэчлэх, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад баримт бичгүүд, тэдгээрийн нэр томъёо тодорхойлолттой уялдуулан боловсруулах” гэжээ. Өмнөх жишиг техникийн шаардлагад параметр гэхээр ямар нэгэн зүйл тусгагдаагүй тул үүнийг юу гэж ойлгох вэ? Мөн бусад техникийн баримт бичгүүд гэдэгт юуг авч үзэх ёстой вэ? Дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?	“Параметр” гэдэгт ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”-д заасан техникийн шаардлага, үзүүлэлтүүд бүхий тоон утгуудыг ойлгоно. “Бусад баримт бичиг” гэдэгт MNS 6598:2023 стандартад заасан “Норматив техникийн баримт бичиг” гэснийг ойлгоно.
8	AASHTO, ASTM, BS, ACI гэсэн гадны стандартуудыг хэрэглэхээр огт тусгахгүй гэсэн үү? Хэрэв үндэсний стандартууд нь алдаа мадагтай, эх материалтайгаа таарахгүй, эсвэл огт байхгүй, мөн зарим нь дотроо гадаад стандартыг хэрэглэхийг шууд заасан бол яах вэ? Үүнээс гадна үндэсний хувилбаргүй учраас тэр чигээр нь хэрэглэхээр жишиг техникийн шаардлагад зайлшгүй оруулмаар гадаадын олон стандарт байгааг хэрхэх вэ?	Олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилтэт стандартыг хэрэглэхээр ТШ-д заасан бол Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэх асуудлыг тодорхой тусгах, мөн ТШ-д тусгагдаагүй үндэсний стандартуудыг судалж, шинэчлэн боловсруулсан төсөлд тусгах.
9	Энэхүү ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нарийвчлан тооцсон зардлын хэмжээ танай төлөвлөсөнөөс илүү гарахаар байвал яаж зохицуулах вэ?	Захиалагч ажлын даалгаврын цар хүрээг үндэслэн шинэчлэн боловсруулах задлын хэмжээг 123.6 сая төгрөгөөр тооцож, батлуулсан.

10	<p>Төслийн онцгой нөхцөлд “...батлагдсан аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, бүртгүүлэхэд Захиалагчтай хамтран ажиллах” гэжээ.</p> <p>a. Шинэчлэн боловсруулсан жишиг техникийн шаардлагын төслийг бүхэлдээ авто замын мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн салбарын ШУТЗ-өөр зөвхөн хэлэлцүүлэхэд хангалттай биш үү? Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага яг юуг нь хянадаг вэ?</p> <p>b. Дээрх заалтад байгаа “аргачлал” гэж юуг хэлээд байна? Тодруулж өгнө үү?</p> <p>c. Дээрх заалтад Захиалагчтай хамтран ажиллах гэдэгт Гүйцэтгэгч ямар үүрэгтэй гэдгийг тодорхой тайлбарлаж өгнө үү?</p>	<p>a) ТШ нь Зам, тээврийн сайдын тушаалаар батлагдах нийтээр дагаж мөрдөгдөх баримт бичиг бөгөөд ЗТСайдын тушаал нь “Захиргааны ерөнхий хууль”-аар Захиргааны хэм хэмжээний акт мөн болох тул тус хуулийн 64.1 дэх заалтын дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй болно.</p> <p>b) “Аргачлал” бус “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” болно. Уг заалтын үгийн алдааг залруулна.</p> <p>c) Холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлэх, хурлаас өгсөн зөвлөмжийн дагуу биелэлт гаргах, Авто замын салбарын инженер техникийн ажилтнууд, мэргэжлийн байгууллагуудаас санал авах болон “Захиргааны ерөнхий хууль”-ийн дагуу шаардагдах баримт бичгийн бүрдлийг бэлтгэн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зэрэг арга хэмжээг ойлгоно.</p>
----	---	---